

ЖУРАМ

Олон улсын оролцоотой (Орос, Монгол улс) «Их сургуулийн ном - 2019, Евразийн ертөнц: боловсрол, соёл, шинжлэх ухаан» Сибирийн бүсийн VIII дахь уралдааны тухай

1. Ерөнхий журам

1.1 «Их сургуулийн ном - 2019, Евразийн ертөнц: боловсрол, соёл, шинжлэх ухаан» Сибирийн бүсийн олон улсын оролцоотой (Орос, Монгол) VIII дахь удаагийн сонгон шалгаруулалтын уралдаан (цаашид “Уралдаан” гэх) нь: зохиогч, зохиогчдын хамт олны бүтээлүүдийг дэмжих, дээд боловсролын байгууллагын дэргэдэх хэвлэлийн газрууд, эрдэм шинжилгээний болон хувийн хэвлэлийн газруудын оюутан, аспирант, мэргэжил дээшлүүлэх сургалтуудын сонсогчдод зориулсан хэвлэлийн эх бэлтгэл, гүйцэтгэл мөн шинжлэх ухаан, шинжлэх ухаан-танин мэдэхүй, сургалт, мэдээллийн болон бусад хэвлэлийн материалуудын уран сайхны чимэглэлийн түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн төслийг урамшуулах зорилгоор зохиогдож байгаа юм.

1.2. Уралдааныг Холбооны Улсын Төсвийн Мэргэжлийн Дээд Боловсролын Байгууллага (ФГБОУ ВО -оросоор) “Байгалийн улсын их сургууль”-д (цаашид “БГУ” гэх) суурилан, 2018.10.20 – 2019.04.20 -ны хооронд явуулна.

1.3. Уралдааны мэдээлийн дэмжлэгийг БГУ-ын шинжлэх ухааны сэтгүүлүүд болон “Университетская книга” сэтгүүл үзүүлнэ.

1.4. Уралдаанд, сургалтын болон шинжлэх ухааны хэвлэлийг уламжлалт унаган хэл дээр (хэвлэмэл) гаргадаг, Орос Монголын зохиогч, зохиогчдын хамт олон, дээд боловсролын байгууллага, шинжлэх ухаан судлалын болон эрдэм шинжилгээний хүрээлэн, нийгмийн болон уран бүтээлийн байгууллагуудын дэргэх хэвлэлийн газрууд, хувийн хэвлэлийн газрууд, тэдгээрийн салбаруудыг оролцохыг урьж байна.

1.5. Оролцох хүсэлтэй хувь хүн, байгууллага, хамт олон захиалгын хуудас (өргөдөл) бөглөн явуулж, хэвлэлийн материалуудаа Уралдааны Зохион байгуулах хороонд ирүүлж танилцуулсны үндсэн дээр Уралдаанд оролцоно.

1.6. Уралдаанд оролцох эрх нь үнэ төлбөргүй.

1.7. Уралдаанд, 2015-2019 онуудад гаргасан, хэвлэлийн стандартад нийцсэн, эрүүл ахуйн шаардлагыг хангасан хэвлэлийг нэр тус бүрээс 2 хувийг хүлээн авна. Сэтгүүлийн хэвлэмэлийг 2018 оны жилийн захиалгын “үдсэн цуглуулга” хэлбэрээр 1 хувиар хүлээж авна.

1.8. Уралдаанд ирүүлсэн хэвлэлүүдэд төлбөр төлөхгүй ба буцааж олгохгүй.

1.9. Уралдаанд оролцож байгаа хэвлэлүүдийн бүрэн жагсаалтыг «Университетская книга» сэтгүүлийн (www.unkniga.ru), БГУ-ийн (www.bgu.ru) цахим хаяг дээр нийтлэнэ.

2. Уралдааны номинаци

2.1. Уралдаанд оролцох хэвлэлийн бүтээлүүдийг дараах чиглэрээр хүлээн авна. Үүнд:

- Орос-монголын харилцаа: түүх; дипломат харилцаа; улс төр; эдийн засаг;
- гүн ухаан-философи; улс төр судлал; нийгэм судлал;
- хэл зүй; хэл шинжлэл; урлаг судлал; соёл судлал;
- сэтгүүл зүй; олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийн харилцаа;
- түүх; археологи; угсаатны зүй;
- хүний цогц судалгаа; сэтгэл зүй; нийгэм дэх хүний экологи ба анагаах ухааны тулгамдсан асуудал;
- сурган хүмүүжүүлэх ухаан; сургалт хүмүүжлийн онол, арга барил;
- хууль эрх зүй; эдийн засаг; удирдлагын шинжлэх ухаан(менежмент);
- Сибирь болон Монголын ард түмний соёл.

2.2. Уралдааны үндсэн номинацууд:

- Орос-монголын харилцааны тухай шилдэг хэвлэл;
- Орос хэл дээр нийтлэгдсэн монгол зохиогчдын шилдэг хэвлэл;
- Монгол хэл дээр нийтлэгдсэн орос зохиогчдын шилдэг хэвлэл;
- Монгол хэл судлахад зориулсан шилдэг сурах бичиг болон орос-монгол толь бичгүүд;
- Орос-монгол хоёр давхардмал хэл дээр гаргасан шинжлэх ухааны болон сургалтын шилдэг хэвлэл;
- Сибирь болон Монголын ард түмний соёлын тухай шилдэг хэвлэл;
- Түүхийн шинжлэх ухааны (сургалтын) шилдэг хэвлэл;
- Хэл зүйн шинжлэх ухааны (сургалтын) шилдэг хэвлэл;
- Хууль зүйн шинжлэх ухааны (сургалтын) шилдэг хэвлэл;
- Эдийн засаг болон удирдлагын шинжлэх ухааны (сургалтын) шилдэг хэвлэл;
- Хүмүүнлэгийн шинжлэх ухааны (сургалтын) шилдэг хэвлэл (гүн ухаан, улс төр судлал, нийгэм судлал буюу социологи, сэтгэл зүй, соёл судлал, урлаг судлал);
- Сэтгүүл зүйн шинжлэх ухааны (сургалтын) шилдэг хэвлэл;
- Сурган хүмүүжүүлэх ухааны (сургалтын) шилдэг хэвлэл;
- Экологи болон байгаль судлалын шинжлэх ухааны (сургалтын) шилдэг хэвлэл;
- Хүний цогц судалгаа, нийгэм дэх анагаах ухаан, биеийн тамир, спортын тулгамдсан асуудлаар шинжлэх ухааны (сургалтын) шилдэг хэвлэл;
- Тогтмол хэвлэгддэг шилдэг хэвлэл;
- Шилдэг шинжлэх ухааны дээд боловсролын сургууль;
- Шилдэг хэвлэлийн төсөл;
- Шилдэг орчуулгын хэвлэл;

— Гадаад хэл дээр нийтэлдэг шилдэг хэвлэл;

— Уралдааны танилцуулгын явцад уншигчдын зүгээс хамгийн их сэтгэгдэл авсан хэвлэл.

2.3. Зохион байгуулах хороо болон Уралдааны шинжээчийн зөвлөл тусгай (нэмэгдэл) номинаци оруулах буюу өөрчлөх эрхтэй.

3. Уралдаанд оролцох өргөдөл хүлээн авах журам.Хэвлэл болон дагалдах материалуудыг явуулах тухай.

3.1. Уралдаанд оролцохын тулд захиалгын хуудас (өргөдөл) бөглөх шаарлагатай. Захиалгын хуудсанд хувь зохиогчдод (Хавсралт 1), хэвлэлийн газар/байгууллагуудад (Хавсралт 2) зориулсан бүртгэлийн маягт, мөн уралдаанд оролцох хэвлэлийн бүтээлүүдийн жагсаалт ба түүний тайлбар (Хавсралт 3) багтаж байгаа бөгөөд материалуудыг энэхүү журам нийтлэгдсэн өдрөөс эхлэн 2019.03.20 дуустал хүлээж авна.

3.1.1. GrigoryevaVN@bgu.ru цахим хаягаар «Университетская книга-2019» гэсэн тэмдэглэлтэйгээр хавсаргаж явуулах баримтууд:

- оролцох өргөдлийн сканердсан хуулбар;

- Уралдаанд танилцуулах хэвлэлийн нэрсийн жагсаалтын сканердсан хуулбар;

3.1.2. Дараах материалуудыг 2019.03.20-с өмнө шуудангаар эсвэл баримт бичиг хүргэгч зарлага (курьер)-р «Университетская книга – 2019» гэж тэмдэглэн, “664003, г. Иркутск, ул. Ленина, 11, Научная библиотека БГУ” –хаягаар явуулна уу:

- оролцох өргөдөл (эх хувь);

- хэвлэлийн нэрсийн жагсаалт (эх хувь);

- уралдаанд оролцох хэвлэлүүд (нэр тус бүрээс 2 хувь);

- оролцогчдийн хүсэлтээр:тухайн нийтлэл, хэвлэлийн хувьд гаргасан хөндлөнгийн санал сэтгэгдэл, зөвлөмжийг захидал хэлбэрээр ирүүлж болно.

4. Уралдааныг явуулах Журам

4.1.Уралдаан дөрвөн үе шаттай явагдана:

4.1.1. Зохион байгуулалт-бэлтгэл (2018 оны 10-р сар – 2019 оны 01 сар) – дээд боловсролын байгууллага болон бусад ном хэвлэлийн газрууд захиалгын хуудас (өргөдөл), хэвлэл (ном сэтгүүл)-ийн нэрсийн жагсаалтаа явуулж,түүнийг хүлээж авах;

4.1.2. Шинжлэн-сонгох (2019.03.20–2019.04.19)–Уралдаанд ирүүлсэн хэвлэлүүдийг тогтоосон шалгууруудын дагуу шинжлэн дүгнэж номинаци буюу ангилал, төрлөөр нь ялагчдыг тодруулна;

4.1.3. Үзэсгэлэн маягийн танилцуулга (2019.04.01 – 2019.04.19)-БГУ-ийн шинжлэх ухааны номын санд уралдаанд ирүүлсэн хэвлэлийн бүтээлүүдийг танилцуулах үзэсгэлэн нээж, сонирхохоор хүрэлцэн ирсэн мэргэжилтэн, нийгмийн шинжлэх ухаан-сурган хүмүүжүүлэх салбарын өргөн хүрээний төлөөлөгчдөд зочлох нөхцлийг бүрдүүлнэ;

4.1.4 Эцсийн дүнг гаргах (2019.04.20)- Уралдааны шагнал гардуулах ёслол явагдана.

4.2. Уралдааны Зохион байгуулах хороог БГУ–ийн захирлын зөвлөмжөөр бүрдүүлэх ба бүрэлдэхүүнийг (www.bgu.ru), «Университетская книга» сэтгүүлийн (www.unkniga.ru) цахим хаяг дээр 2018.12.01-с хэтрэхгүй нийтлэнэ.

4.3. Зохион байгуулах хороо нь уралдаанд оролцох хүсэлтийн захиалгын хуудас (өргөдөл) болон ирүүлсэн хэвлэлийн материал, тэдгээртэй холбоотой захидал хэлбэрээр ирүүлсэн санал сэтгэгдэл, зөвлөмжийг хүлээн авч “үзэсгэлэн-танилцуулга”-д тавих ажлыг зохион байгуулах бөгөөд Уралдааны мэдээллийн дэмжлэгийг БГУ-ийн (www.bgu.ru), «Университетская книга» сэтгүүлийн (www.unkniga.ru) цахим хаягаар дамжуулан явуулах болно.

4.4. Шинжээчдийн зөвлөлийг, Зохион байгуулах хорооны гишүүдийн зүгээс санал болгосон, нэр хүнд бүхий эрдэмтэд, соёл, боловсрол, хэвлэлийн салбарын зүтгэлтнүүдийн дундаас сонгож бүрдүүлнэ.

4.5. Шинжээчдийн зөвлөл нь үнэлгээний шалгуурыг боловсруулж, уралдаанд ирүүлсэн хэвлэлийн материалуудыг шинжлэн судлах үйл явцыг тогтоон шагналт байр эзлүүлж, үүнтэй холбоотой маргаан болон санал зөрөлдөөнийг шийдвэрлэнэ.

4.6. Шинжээчдийн зөвлөл бүх шийдвэрийг хамтдаа нэг саналын хэлбэрээр шийдвэрлэх ба протоколоор боловсруулна.

5. Уралдааны явцын дүн болон шагнал

5.1. Уралдааны ялагчдыг оролцогчийн диплом, баярын бичиг, гэрчилгээ болон бусад шагналуудаар шагнана.

5.2. Уралдаанд оролцогчдод шагнал гардуулах хүндэтгэлийн арга хэмжээ 2019.04.20-нд Байгалийн улсын их сургууль (БГУ) дээр явагдах бөгөөд ёслолын арга хэмжээ болох газар, эхлэх цагийг урьдчилан мэдэгдэх болно. Уралдааны явцын дүнг танилцуулах арга хэмжээг одоогоор Монгол улс (Улаанбаатар хот)-д явуулахаар төлөвлөж байна.

5.3. Уралдааны дүнг «Университетская книга» сэтгүүлийн (www.unkniga.ru) болон Байгалийн улсын их сургуулийн (www.bgu.ru) цахим хаяг дээр нийтлэнэ.

5.4. Уралдаанд оролцсон хэвлэлийн бүтээлүүдийг БГУ-ийн Шинжлэх ухааны номын санд шилжүүлэх болно.